

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

МОНГОЛЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ОЮУТНУУДЫН МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Д.Дагиймаа*

*ХУИС-ийн Мэдээлэл, харилцаа менежментийн сургуулийн захирал, доктор (Ph.D), профессор

Түлхүүр үг: Мэдээллийн боловсрол, оюутан, их, дээд сургуулиуд

Мark Thompson “Хуурамч мэдээлэл бол шинэ зүйл биш бөгөөд дижитал систем үүнийг хөгжүүлж, дэлгэрүүлж байна” гэжээ¹. АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн мэдээнд “Buzzfeed news” шинжилгээ хийж ISIS зэвсэг худалдсан тухай хуурамч мэдээлэл фэйсбүүкт илүү шэйр, коммент, лайк авсан тухай мэдээлжээ. Дижитал систем өнөө цагт түүнийг улам дэлгэрүүлж ардчилалд заналхийлэх түвшинд хүрчээ. Ийм учраас баримтыг шалгах үйлчилгээ чухал болж байна. Нөгөө талаас “...энэ цаг үед дэлхий даяар бичиг үсэг тайлагдалтаас илүү мэдээллийн боловсрол гэх зүйл чухал байр суурь эзлэх болсон билээ”² гэсэн судлаачдын дүгнэлттэй санал нийлэхгүй байх аргагүй юм.

Хүмүүс мэдээллийн бодитой эсэхийг ч анхаарахаа больсон энэ цагт хуурамч мэдээлэлтэй тэмцэх, түүний нөлөөнд автахгүй байх талаар дэлхийн улс орнууд хэлэлцэж эхэлсэн байна. Манай оронд ч гэсэн энэ талын судалгаа хийгдэж, форум уулзалтууд зохион байгуулагдах болсон. Үүний үр дүнд хэвлэл мэдээллийн суурь

боловсролын тухай ойлголт нийгэмд хурдацтай тархаж олны хараанд орж байна. Өөрөөр хэлбэл, одоо багш нар сурагчид руу чиглэж, тэдэнд хэвлэл мэдээллийн боловсролтой байхын чухлыг ойлгуулж байна.

Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн тухай суурь мэдлэг эзэмшинэ гэдэг нь мэдээллийн хэрэгслийг олж авах, мэдээллийн агуулгад дүн шинжилгээ хийх, шинэ мэдээлэл үүсгэх, мэдээллийн агуулгын талаар тунгаан бодох мөн мэдээллийн дагуу шийдвэр гаргах, арга хэмжээ авах зэрэг олон чадварыг эзэмшсэн байхыг хэлнэ. Харин НҮБ-аас хэвлэл мэдээллийн боловсролыг унших, ойлгох, нухацтай бодохын нийлбэр хэмээн тодорхойлдог.

Мэдээллийн тухай суурь мэдлэг нь олон оронд дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт орсон байдаг. АНУ-ын хэвлэл мэдээллийн боловсролын түүх буюу энэ талаар хийгдсэн анхны алхмууд 1960 оны сүүл үеэс эхэлжээ. Харин Их Британи улсын хувьд хэвлэл мэдээллийн боловсрол АНУ-тай харьцуулахад 40 орчим жилийн өмнө суурь нь тавигдсан байдаг ба 1933 онд Leavis болон Thompson нарын “*Culture and Environment*”: *The Training of Critical Awareness* гэх зэрэг ном хэвлэгдэж, энэ сэдэв аль хэдийнээ

олны хараанд орсон байжээ. 1960 оноос буюу зарим улсуудтай харьцуулахад хожуу эхэлсэн АНУ-ын хэвлэл мэдээллийн боловсролын хөгжлийг хэвлэл мэдээллийн боловсролын тухай сэдэв хөндөгдөж эхэлсэн үе, албан ёсоор боловсролын хэмжээнд авч үзэн хөгжүүлсэн үе, хурдацтай хөгжүүлэх гарааг эхлүүлж бусад орнуудтай хөл нийлүүлэн алхаж эхэлсэн шилжилтийн үе гэсэн гурван үед хуваан авч үздэг.

1960 оны сүүл үеэс АНУ-д анх удаа боловсролын байгууллагуудын багш нар, удирдах албан тушаалтнууд хэвлэл мэдээллийн боловсролын тухай сэдвийг хөндөж, үүнтэй холбогдуулан арга хэмжээ авах, хөгжүүлэх шаардлагатай талаар хэлэлцэж эхэлжээ. Ингээд багш нар хамгийн анх сурагчдад энэ тухай ойлголт өгөх үүднээс хичээлийн хөтөлбөртөө хэвлэл мэдээллийн боловсролын тухай суурь мэдлэгийг түгээж эхэлжээ. Хоёрдугаар үе шат буюу 1970 оноос мэдлэг мэдээлэл олгох зорилгоор хичээлийн хөтөлбөр боловсруулан зааж эхэлсэн байна. Гуравдугаар үе шатыг бүхэлд нь хэвлэл мэдээллийн боловсролын ахицтай хөгжил эхэлсэн томоохон шилжилтийн үе гэж нэрлэж болох юм. 1980 оны сүүл үеэс хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон үзэгчид хоёул утга учрыг бий болгогч юм гэдэг ойлголт дэлгэрч, үзэгчид мэдээ, мэдээллийг шүүмжлэлт сэтгэлгээний шүүлтүүртэй хүлээн авах

нь маш чухал чадварт тооцогдох болжээ.³

Манай улсын хувьд ЕБС-иудад “Иргэний боловсрол” хичээлийн агуулгад нэг цаг хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдлэг, мэдээлэл авах, ашиглах тухай хичээлийг орж байна. Монголчуудын хэвлэл мэдээллийн боловсролын түвшинг тодорхойлсон өргөн цар хүрээтэй албан ёсны судалгаа статистик ховор байна. 2012 онд ЕБС-ийн сурагч, багш нарын дунд Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн хэвлэл мэдээллийн боловсролыг тандах шүүмжлэлт сэтгэлгээгээр мэдээ мэдээлэлд хандах гэдэг үзүүлэлт хангалтгүй байна хэмээн дүгнэжээ. Мөн ЕБС-ийн сурагчид гэлтгүй багш нарт мэдээллийн боловсрол дутмаг байв.

Ийнхүү олон нийтийн анхааралд орж байгаа тус сэдвийн хүрээнд хийгдсэн судалгааг өргөжүүлэхээр Монголын их, дээд сургуулиудын оюутны мэдээллийн боловсролыг тандах судалгаа гүйцэтгэв. Монгол улсад 2017-2018 оны байдлаар 96 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байв⁴. Эдгээрээс МУИС, ШУТИС, АШУҮИС, ХИС, ШИХИХУТУГ, Этүгэн, МУБИС, ХААИС, СУИС, СИТИ, МУИС, СЭЗИС, Зохиомж ДС, ҮБХИС, Идэр ДС, ОУСДС, УБЭИС, Ач ИС, ОУБИС, ХСИС, ОТИС, ХҮИС зэрэг 22 их, дээд сургуулийн 560 оюутныг хамрууллаа.

Хүснэгт №1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт

Хүн ам зүйн үзүүлэлт		Тоогоор	Хувиар
Хүйс	Эр	235	42%
	Эм	325	58%
	I	190	21%
	II	171	30%
	Курс	III	105

IV	78	14%
V+	16	3%

Хүйсийн харьцааг харахад эрэгтэй 42 хувь, эмэгтэй 58 хувь байна. 2018 оны байдлаар Монгол улсад дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 58 хувийг эмэгтэй, 42 хувийг эрэгтэй суралцагч бүрдүүлж байгаа ба хүйсийн ялгааны индекс 1.38 байсан учир судалгаанд оролцогчдын хүйсийг энэ тооны жишгээр судалгаагаа авсан болно. Судалгаанд оролцогч оюутнуудын 190 буюу 34 хувийг нэгдүгээр курс, 171 буюу 30 хувийг хоёрдугаар курс, 105 буюу 19 хувийг гуравдугаар курс, 78 буюу 14 хувийг дөрөвдүгээр курсынхан эзэлж буй ба үлдсэн гурван хувийг V, VI, VII болон магистрын ангийн оюутнууд бүрдүүлж буй юм.

Бидний судалгаагаар оюутнуудын 92 хувь нь нийгмийн сүлжээнээс, 56 хувь нь телевиз, мэдээллийн сайтаас мэдээлэл авдаг хэмээжээ. Харин

сэтгүүлээс 13%, сониноос 6%, радиогоос 2% нь мэдээлэл авдаг байна. 12-17 настай хүүхдүүдийн мэдээлэл авдаг гол эх сурвалж бол интернет 92%, найз нөхдөөсөө 60%, гэр бүлийн хүмүүсээс 40%, телевизээс 35% бөгөөд сонин, сэтгүүл зэрэг уламжлалт хэрэгслүүдийг бага ашиглаж байгааг өмнөх судалгаанууд баталсан..⁵ МХХ-ийн судалгаагаар Монголчуудын мэдээлэл авдаг гол эх сурвалжид интернет жагсаж байгаа. Энэ хандлага Монголд төдийгүй дэлхий дахинд залуусын дунд илүү хүчтэй байна. Ройтерс интститутын судалгаагаар бүх улс орны ихэнх хүн нийгмийн сүлжээний эх сурвалжид сонинхоос илүү итгэж байна гэдэг нь харагджээ. 1/10-ээс илүү хувь /12%/ нь нийгмийн сүлжээ сайтуудыг мэдээллийн гол эх сурвалж гэж үзэж байгаа бол 25-аас доош насныхны хувьд 25 хувь нь ийн үзэж байна⁶.




График №1. Оюутнуудын МХ-д итгэх итгэл

Оюутнууд мэдээллээ фэйсбүүк, инстаграмм, твиттэрээс авдаг ч уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэлд илүү итгэдэг болохыг доорх графикаас харж болно. Залуусын 381 буюу 68 хувь нь телевизийн, 189 оюутан /34%/ радиогийн, 145 /26%/ сонины мэдээлэлд хамгийн итгэл үнэмшилтэй ханддаг байна. Харин фэйсбүүкт 298 /53%/, инстаграмд 223 /40%/ оюутан эргэлздэг гэжээ. Мэдээллийн үйлдвэрлэл өргөжиж фэйсбүүк болон бусад платформ мэдээллийг бодлогогүй дамжуулж байгааг тэд ойлгож, шүүлтүүртэй ханддаг байна гэж дүгнэж болохоор байна.

Хэвлэл мэдээллийн боловсрол гэдэг нь мэдээллийг хүлээн авагч төдийгүй, мэдээллийг бусадтай хуваалцагч хэн бүхэнд хамаатай юм. Мэдээллийн сувгуудаар хэр их худал мэдээлэл

цацдаг болохыг асуухад оюутнуудын 44 хувь заримдаа, 38 хувь ихэндээ, 11 хувь байнга, 7 хувь нь ховор гэжээ. Оюутнуудаас хуурамч мэдээллийн тухай лавлахад 86 хувь нь худал мэдээлэл түгээж байгаагүй гэж хариулсан бол 9 хувь нь мэдэхгүй хэмээжээ. Харин худал мэдээлэл бүтээж, түгээж байсан гэж хариулсан 5 хувьд тооцогдох оюутнуудыг дотор нь хүйсээр нь авч үзвэл эрэгтэй оюутнууд дийлэнх байна. Судалгаанд оролцогчдын 32 хувь нь хуурамч мэдээний улмаас хохирч байсан хэмээжээ. Олон нийт уншиж буй мэдээллийнхээ эх сурвалжийг нь харах, ардаа ямар нэг зорилго агуулж бичсэн байна уу гэдгийг тунгаах гэх мэт энгийн алхмуудыг хийж хэвших нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгдөг.




График №2. Мэдээлэл хүлээж авахдаа эх сурвалжийг нь хардаг эсэх

Судалгаанд оролцогч оюутнуудын 67 хувь мэдээ, мэдээлэл хүлээж авахдаа эх сурвалжийг нь хардаг, 21 хувь заримдаа, 12 хувь үгүй буюу мэдээ, мэдээлэл хүлээж авахдаа эх сурвалжийг нь анзаардаггүй хэмээн

хариулсан байна. Аливаа мэдээ, мэдээллийг хүлээж авахдаа эх сурвалжийг нь харна гэдэг нь хэвлэл мэдээллийн боловсролын нэг үзүүлэлт бөгөөд ннэ үзүүлэлтийг сургуулиар нь авч үзвэл БХҮИС, ХИС, МУБИС-ийн

оюутнууд 80-90 хувьтай буюу бусад сургуулийн оюутнуудаас илүү мэдээлэлд хянамгай ханддаг байна.

Мэдээллийн боловсрол бол олон янзын мэдээллийн хэрэгслийг бүрэн ашиглах чадвар юм. Үүний тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бодит байдлыг хэрхэн тусгадаг, хэн нэгний ашиг сонирхлын төлөө бодит байдлын тусгалыг өөрчлөн харуулдаг эсэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээ, нийтлэл, нэвтрүүлгүүд хэрхэн хийгддэг, үүний ард ямар нэгэн ашиг сонирхол нуугддаг эсэхийг мэдэж байх нь чухал. Оюутнуудаас ХМХ эзэмшдэг хэн нэгэн хүний тухай мэдэх эсэхийг лавлахад 87 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн ба 13% нь хувьдаа хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хүмүүсийг мэддэг гэсэн хариулт өгчээ.

Уг судалгаа хоёр хэсэгтэй бөгөөд Б хавсралт дахь асуултаар А хавсралтад ил өгөгдсөн асуултыг далд утгаар шалгасан юм. Ингэхдээ фэйсбүүкийн пост дахь хуурамч мэдээллийг хэрхэн нягтлах эсэхийг шалгаж асуусан юм. Мэдээллийн суурь мэдлэгтэй байх нь мэдээлэл хүртэх, дүн шинжилгээ хийх, бүтээх, эргэцүүлэх, үйлдэл хийх гэсэн үе шаттай үйл явц байдаг. Тийм учраас асуулгыг 4 алхамтай гүйцэтгэсэн юм. Эхний алхамаар найзынхаа фэйсбүүкт постолсон хуурамч мэдээлэлд

итгэсэн эсэх, дараагийн алхам нь уг мэдээлэлд эргэлзсэн хэсэг нь Википедиагаар шалгах, гурав дахь шат нь мэдээллийн шар сайтаар нягтлах, дөрөв дэх алхам нь мэдээллийн найдвартай эх сурвалжаар баталгаажуулах гэсэн асуулгатай байв. Хавсралт А-д өгөгдсөн ил асуултаар мэдээлэл авахдаа эх сурвалжийг нь хардаг, худал мэдээллийг ялгадаг, түгээддэггүй гэж хариулсан ч шалгах асуултад буюу Фэйсбүүкт найзынхаа бичсэн постонд буюу худал мэдээлэлд итгэдэг гэж хариулт өгсөн оюутан /63%/, үүнийг хүйсээр авч үзвэл эмэгтэй 51 хувь, эрэгтэй 49 хувь байна. Ийнхүү манай улсад зөвхөн өсвөр үе, хүүхэд гэлтгүй насанд хүрсэн хүмүүст ч мэдээллийн боловсрол дутмаг байгаа нь хуурамч мэдээнд итгэж буй хүмүүсийн тоогоор батлагдаж байгаа юм. Харин дээрх мэдээлэлд эргэлзсэн хэсэг оюутнууд Википедиагаар шалгана гэж хариулсан /23%/ хэсгийг курсээр нь авч үзвэл нэгдүгээр курсын оюутнууд хамгийн өндөр буюу 37 хувьтай байна. Курс ахих тусам энэ тоо буурч байна. Үүнээс улбаалан оюутнууд их, дээд сургуульд суралцан курс ахих тусмаа академик түвшиний боловсрол эзэмшихийн хэрээр мэдээ, мэдээлэлд хандах хандлагад зөв ахиц гарч буйг харах боломжтой.



График №3. Википедиа хуудаснаас мэдээллээ баталагжуулдаг эсэх

Википедиа нь хүссэн хүн бүр тухайн хуудаст байрлах мэдээлэлд засвар хийх боломжтой нээлттэй хуудас юм. Оюутнууд хичээлийн бие даалтын ажлыг гүйцэтгэхдээ энэ хуудсыг түгээмэл ашигладаг. Судалгааны 3, 4 дүгээр алхмыг хийсэн оюутан тун цөөн буюу 14 хувьтай байна.

Дүгнэлт. Бидний судалгаагаар Монголын их, дээд сургуулиудын оюутнуудын мэдээллийн боловсрол тааруу байна. Оюутнууд уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэдэг хэдий ч мэдээлэл авдаггүй, сошиал орчныг илүүд үздэг, хуурамч мэдээ, мэдээлэлд итгэх хандлагатай, тухайн мэдээллээ нягтлалгүй цааш түгээдэг байна.

ЕБС-д мэдээллийн боловсрол олгох хичээлийн эхлэл тавигдаж байгааг дээр дурдсан. Харин их, дээд сургуулийн оюутнуудад “critical thinking” хичээл заах нь зүйтэй гэж үзэж байна. Америкийн их сургуулиудад Liberal arts education буюу боловсролтой хүний эзэмшвэл зохих хүмүүнлэг, нийгмийн ухаан, байгалийн ухааны салбарыг хамардаг хичээлүүд бий. Эдгээр нь ямар нэгэн мэдлэг эзэмшүүлэх сургалт бус харин мэдлэгийг оюун ухаандаа боловсруулах үйл явц, шинэ санааг урлах чадвар, дадал эзэмшүүлэх сургалт буюу манай их, дээд сургуулиудын хөтөлбөрт байдаг ерөнхий суурь хичээл юм. Гэхдээ мэдээллийн эрин зуунд “critical thinking” хичээл чухал болох нь дээрх судалгаагаар нотлогдож байна. Энэ хичээл асуудлыг олон өнцгөөс харж, зөв шийдлийг олох чадвартай, ертөнцийг үзэх дэлгэр үзэлтэй, учир шалтгаангүй хийрхэл, туйлшрал зэрэгт үл автах бодит байдлыг учир зүйтэйгээр таних сэтгэлгээг төлөвшүүлдэг байна.

Өөрөөр хэлбэл, техник технологи хөгжсөн өнөөгийн нийгэмд хүн зөвхөн уншиж бичиж чаддаг байх нь хангалтгүй

болсон. Өнөөдөр хүн мэдээлэлтэй яаж харьцаж байна, сошиал орчинд хэрхэн биеэ авч явж байна гэдэг нь тэр хүний төлөвшил, сахилга бат, хэн гэдгийг нь тодорхойлох болсон. Олон нийт арилжааны сурталчилгааг хүртэл бодит мэдээллээс салгаж чадахгүй үнэн гэж хүлээж авдаг өнөө үед мэдээллийн суурь боловсролын асуудал маш чухал юм. Мэдээллийн боловсролтой иргэд л мэдээллийн үр өгөөжийг илүүтэй хүртэж, илүү амжилтад хүрч тэр хэрээр хүний хөгжил ч, нийгмийн хөгжил ч урагшлан ахиж дэвших юм.

Ишлэл

1. Thompson, Enough Said: What's Gone Going Wrong with the Language of Politics?, Bodley Head, 2016.
2. <https://ikon.mn/opinion/18bo>
3. Guo-Ming Chen. 2007. Media (Literacy) Education in the United States.
4. <https://mecss.gov.mn/media/uploads/d199c4f8-e330-47b7-97f3-c110748d620a.pdf>
5. Хэвлэлийн Хүрээлэн, Швейцарийн хөгжлийн агентлаг. 2011. “Хэвлэл мэдээллийн хариуцлага, сэтгүүл зүйн хэм хэмжээ” судалгааны тайлан. УБ., 2011.
6. Journalism, media, and technology trends and predictions 2017. Reuters Institute. p 7

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Reuters Institute. 2017. Journalism, media, and technology trends and predictions.
2. Дойче Велле академи. 2008. Мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн тухай суурь мэдлэг: Сургагч багш нарт зориулсан гарын авлага. УБ
3. Guo-Ming Chen. Media (Literacy) Education in the United States. 2007
4. Хэвлэлийн Хүрээлэн, Швейцарийн хөгжлийн агентлаг. “Хэвлэл мэдээллийн хариуцлага, сэтгүүл зүйн хэм хэмжээ” судалгааны тайлан. УБ., 2011
5. www.mecss.gov.mn

6. www.ikon.mn

Summary

Every country in the world is eager to focus on the importance of media literacy as it focuses on reducing the spread and treats of fake news. In recent years, our state and non governmental organizations have become active in media literacy programs, research, knowledge sharing sessions and conversions. In the Age of Information,

the competence of media and information literacy of higher education students directly affect the quality and efficiency of their study, work and life. This study is aimed to investigate the media literacy of students in universities and colleges of Mongolia. We collected and analyzed data from 560 students who was studying 22 universities and colleges. According to the research results, the media literacy of Mongolian university students is poor.